

**Төсвийн ерөнхийлөн захирагч /сайд/ нараас
аймгийн Засаг даргатай байгуулсан
үр дүнгийн гэрээний биелэлт.**

Аймгийн Засаг дарга Монгол улсын төсвийн удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 23.1, 51.1.1-8 дахь заалтын дагуу Монгол улсын Засгийн газрын гишүүн тухайн салбарыг хариуцсан сайдтай бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээг Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 8.1.4 дэх заалтыг үндэслэн СЭЗЯ-ны сайдын 2002 оны 11 дүгээр сарын 2-ний өдрийн 355 дугаар тушаалаар батлагдсан загварын дагуу хийж, улирал тутмын үр дүнгийн тайланг 364 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу холбогдох яамдад хүргүүлж байв.

Оны эцэст яам тус бүрийн гэрээний биелэлтийг тооцон тухайн яамдад хүргүүлэв.

Аймгийн Засаг дарга 2009 онд Монгол улсын тэргүүн шадар сайд, шадар сайд, 8 яамтай, бүгд 42 ангиар нийт 158 бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ хийж, түүнийг хангах ажлыг орон нутагтаа зохион байгууллаа./Үр дүнгийн гэрээний биелэлтийг хавсаргав/.

Аймгийн Засаг дарга, сайд нартай байгуулсан гэрээгээ хангах ажлыг үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2009 оны зорилтыг хангах ажилтай нягт холбон зохион байгуулж, үүнд аймгийн ЗДТГ, өөрийн эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, албадын хүч анхаарлыг төвлөрүүлэн ажилласнаар дэвшүүлсэн зорилт төлөвлөсөн ажлууд цаг хугацаандаа хийгдэж гэрээнд заагдсан бүтээгдэхүүнийг цаг хугацаандаа нийлүүлэв.

Яамдын сайд нар тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай санхүүжилтийг графикийн дагуу хийж байсан нь ажлын доголдол гаргахгүй төрийн үйлчилгээг жигд хэвийн чанартай иргэдэд үзүүлэх боломжийг бүрдүүлж байлаа.

Яамдын сайд нар өөрсдийн хариуцсан салбарын чиглэлээр орон нутагт нийлүүлэхээр Засаг даргатай байгуулсан гэрээгээ хангуулахад биечлэн тусалж аймгийн Засаг даргын тавьсан асуудлыг шийдвэрлэхэд шуурхай хандаж холбогдох арга хэмжээг авч байсан нь аймгийн нийт ажлын үр дүнг ахиулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хангахад чухал түлхэц болж байна.

Өнгөрсөн оны аймгийн Засаг даргаас яамдын сайдтай байгуулсан гэрээний 154 бүтээгдэхүүний 92.1 хувь нь буюу 1 биелэлтийн оноо 4.5 байна. Яамдын сайд, аймгийн Засаг дарга нарын хамтын ажиллагааны үр дүнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн орон нутагт холбогдох заалтын биелэлт 90.5 хувьтай байна.

Дүгнэлт, зорилт.

2009 он бол Монгол Улсын их хурлаас баталсан Засгийн Газрын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх гарааны он гэдгээрээ онцлог жил байсан тул өөрийн аймгийн бодит нөхцөлд тохируулан олон талын судалгаа тооцоо, өмнөх жилүүдийн ололт туршлага дээр тулгуурлан үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний зорилтуудыг шахуу тооцон төлөвлөж аймгийн эдийн засгийн чадавхийг сайжруулах, нийгмийг хөгжүүлэхэд ажиллах хүн

хүч, санхүү, байгалийн нөөц боломжийг дайчлан ажиллаж ирсэний үр дүнд эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл тавьсан зорилт амжилттай хэрэгжлээ.

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн иргэдийн хичээл зүтгэл, идэвхи санаачлга, Хөвсгөл нутгаа гэсэн бүтээлч үйл ажиллагааг төвлөрүүлж, дотоод нөөц бололцоо, эдийн засгийн чадавхийг бүрэн ашиглах замаар аймгийн эдийн тогтвортой өсөлтийг хангаж, орон нутгийн бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлэх, иргэдийнхээ амьжиргааны түвшинг дээшлүүлэх явдал мөн гэж үзэн үндсэн 5 зорилтыг дэвшүүлж хэрэгжүүлэв.

Хөвсгөл нутгаа хөгжүүлэхэд нутгийн эрдэмтэн мэргэд, төр нийгмийн зүтгэлтнүүд, бизнесменүүд, нутгийн зөвлөлийнхөн, нутгаа гэсэн сэтгэлтэй бүхний хүчин зүтгэл, нэмэр хандив оролцоог нэгтгэх зорилгоор зохион байгуулсан “Хөвсгөл-Хөгжил” форумаас гаргасан уриалга, шийдвэр түүнээс гарч байгаа ажлын эхлэлүүд аймаг орон нутгийн хөгжлийн асуудлаар төлөвлөсөн зорилтоо хэрэгжүүлэхэд бодит хувь нэмэр болж байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан шинээр хийж бүтээх бодит ажлуудыг орон нутгийнхаа нөөцийг бүрэн дайчлан ашиглаж, үйлдвэрлэл үйлчилгээг буй болгох, аялал жуулчлалыг хөгжүүлэх, томоохон хөрөнгө оруулалт шаардагдах, барилга байгууламж, дэд бүтцийн асуудлыг улсын төвлөрсөн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж, төсөл арга хэмжээнд хамруулах, салбарын яам, агентлаг, УИХ-ын гишүүдэд тавьж тэдгээрээс дэмжлэг тусалцаа авах замаар хэрэгжүүллээ.

Үүний үр дүнд 2009 онд аймгийн орон нутгийн орлогын төлөвлөгөөг 126.8 хувиар биелүүлж, орон нутгийн төсвийн өрийг бүрэн барагдуулж, орон нутгийн төсвийн авлагыг 75 хувь, улсын төсвийн өрийг 48.6 хувь тус тус бууруулж, аймгийн орон нутгийн төсвийн орлогын дансанд 680 гаруй сая төгрөгийн үлдэгдэлтэй гарлаа.

2010 оны эрхэм зорилт:

2010 оныг аймгийн хэмжээнд “Төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, иргэдтэй ажиллах жил”-ээр зарлаж оны эхэнд бүх сумд болон хэлтэс албад, төсвийн бүх байгууллагын удирдлагуудыг оролцуулан нээлт, хийж жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталж, аймаг болон сумдад Зохион байгуулах хороо байгуулан ажиллаж байна. Энэхүү жилийн ажлын хүрээнд Аймгийн төрийн албан хаагчдын анхдугаар зөвлөгөөнийг 2 дугаар улиралд зохион байгуулахаас гадна төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн зорилт болсон төрийн албан хаагчдын чадавхийг дээшлүүлж, Төрийн албаны стандартыг бүх шатны төрийн байгууллагуудад хэвшүүлж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилтыг тавьсан болно.

Монгол улсын мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг батлан мөрдөж эхэлсэнтэй уялдуулан “Хөвсгөл аймгийн эдийн засаг нийгмийг 2008-2015 онд хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан Аймгийн ИТХ-аар батлуулан Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил жилийн үндсэн чиглэлд тусган мөрдөж байна.

Аймгийн ЗДТГ-ын 2010 оны эрхэм зорилт нь тухайн нөхцөл байдалд нийцсэн бодлогын үндсэн дээр төрийн албаны стандартуудыг чанд мөрдөж Засгийн газрын болон аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөсөн төлөвлөгөө, хөтөлбөр үндсэн чиглэлийг хугацаанд нь биелүүлж,

хөрөнгө оруулалтын өгөөж, үр ашгийг дээшлүүлэн иргэдийнхээ амьжиргааны түвшинг сайжруулах явдал мөн.

Энэхүү зорилтыг хангахын тулд:

Дээрх “Төрийн албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлж, иргэдтэй ажиллах жил”-ийн хүрээнд төлөвлөсөн ажлаа эрчимжүүлэн, төсвийг хэмнэлттэй зүй зохистой зарцуулж иргэдийн оролцоо, орон нутгийн нөөц боломжинд тулгуурлан санаачилгатай ажиллаж, аймгийн ЗДТГ-ын болон төрийн захиргааны бүх шатны байгууллага, тэдгээрийн аппаратын хүчийг тухайн оны дэвшүүлсэн зорилтоо хангах , аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн заалт бүрийг биелүүлж, үр дүнд хүрсэн байхад чиглүүлэхээс гадна Засгийн газар, яам агентлагуудтай нягт хамтран ажиллаж тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүдийн дэмжлэг тусламжийг авч ажиллах болно.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.ТӨМӨРБААТАР

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС
САЙДУУДАЙ БАЙГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН
НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

№	Байгууллагуудын нэр	2009 оны төлөв	2009 оны гүйцэтгэл	Биелэлт
1	Нийт дүн			
2	Улсын төсвийн дүн	25126676.3	25248239.2	100.4
II	Тэргүүн шадар сайд	69289.0	69289.0	100
2	СХЗ төв	69289.0	69289.0	100
	Шадар сайд	895176.1	890952.1	99.5
1	Онцгой байдлын хэлтэс	480607.8	476383.8	99.1
1	Улсын нөөцийн салбар	23168.8	23168.8	100.0
1	Хүүхдийн төлөө хэлтэс	691080.00	691080.00	100
1	Мэргэжлийн хяналтын газар	322291.5	322291.5	100
III	Байгаль орчны сайд	740741.0	740241.0	99.9
3	Байгаль орчны алба	225117.1	224617.1	
1	УЦУОШ-ий төв	515623.9	515623.9	100
V	Хууль зүйн дотоод хэргийн сайд	652673.8	709824.0	108.7
1	Аймгийн Цагдаагийн хэлтэс	652673.8	709824.0	108.7
VI	БСШУ сайд	15986467.1	16067301.3	100.5
1	ЕБС-ууд	11362222.8	11387304.2	100.2
2	Хүүхдийн цэцэрлэг	2769875.9	2836209.4	102.4
3	Боловсролын соёлын төв	117114.1	158565.7	135.4
4	Музей	56025.5	59890.5	106.9
5	Номын сан	45929.7	48081.7	104.7
6	ХДТ	312908.8	317923.1	101.6
7	Сумдын соёлын төв	442392.9	454476.5	102.7
8	Газар хөдлөлийн станц	15997.6	15997.6	100.0
9	МСҮТ	863999.8	788852.6	91.3
VII	Эрүүл мэндийн сайд	6061862,2	6061163,2	100.0
1	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	2142049.5	2142049.5	100.0
2	Эрүүл мэндийн газар	352371.9	350962.9	99.6
3	БГХӨТ төв	128481.1	128218.7	99.8
4	Сумын хүн эмнэлэг	31203549.0	31233057.	100.1
5	Өрхийн эмнэлэг	241220.3	241220.3	100.0
6	БТС хороо	77384.5	72462.4	93.6
VIII	ХХААХҮЯам	199311.7	199311.7	100.0
1	ХХААЖДҮГ	199311.7	199311.7	100.0
X	НХХЯ	344003.5	333005.0	96.8
1	Аймгийн Асрамжийн газар	144930.0	133931.5	92.4
2	Ахмадын хороо	12437.2	12437.2	100
3	ХХҮХ	186636.3	186636.3	100
XI	Үндэсний статистикийн газар	28866.4	28866.4	100
1	Статистикийн хэлтэс	28866.4	28866.4	100
XII	БХБЯ /барилга хот байгуулалтын/	148285.5	148285.5	100
1	Газрын харилцаа, геофизи зураг зүйн газар	66673.2	66673.2	100
2	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар	81612.3	81612.3	100

Хянасан: СТСХ-ийн ерөнхий санхүүч

Д.Гэрэлчулуун